



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/557

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 31 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авч өндөр амжилт үзүүлж үе тэнгийн суралцагчдаа манлайлж, үлгэр дуурайлал үзүүлсэн тул Э.Дөлгөөн, Г.Номин-Эрдэнэ, Б.Болортуяа, Б.Даваажаргал нарт Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг үзүүлсүгэй.
2. Сургалтын төлбөрийн дэмжлэгт шаардагдах 12,680,000 (арван хоёр сая зургаан зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР